



# АРХАНГАЙ АЙМГИЙН ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН НЭГДСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ХУРААНГУЙ ТАЙЛАН

**Аудитын код:  
АРА-2026/02-1/СТА-НА-НТГ**

ЦЭЦЭРЛЭГ ХОТ

**2026 он**



+976-7033-3141  
+976-7033-2860



Arkhangai@audit.gov.mn  
Audit.mn



## АУДИТ ХИЙХ ҮНДЭСЛЭЛ, БҮРЭН ЭРХ

# АУДИТЫН ЗОРИЛТ

## АУДИТЫН ХАМАРСАН ХҮРЭЭ

Аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2025 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайланд нэгтгэгдсэн байгууллагуудын тайлан мэдээ, аймаг, сумдын ИТХ-ын хуралдааны тогтоол, Сангийн яамнаас Архангай аймгийн 2025 оны аймгийн төсвийн суурь, орлого зарлагыг хянаж ирүүлсэн тооцоо, ОНХС, засаг дарга данс, аймгийн хөгжлийн 2025 оны төлөвлөгөө, түүний хэрэгжилт болон бусад судалгаа, материалд тулгуурлан аудитыг гүйцэтгэв.

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8.9.4 дэх заалтын дагуу аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2025 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлд аудит хийв.

Архангай аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2025 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайланг шалгаж, дүгнэлт, зөвлөмж гарган аймгийн ИТХ болон төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлэхэд аудитын зорилт чиглэгдлээ.

### УГ ЗОРИЛТЫГ ХАНГАХЫН ТУЛД ДАРААХ ЧИГЛЭЛЭЭР АУДИТЫГ ГҮЙЦЭТГЭЛЭЭ. ҮҮНД:

- ✓ Орон нутгийн 2025 оны төсвийн орлогыг бодитой төлөвлөж, бүрэн төвлөрүүлсэн эсэх
- ✓ Орон нутгийн 2025 оны төсвийн зарлагыг үндэслэлтэй төлөвлөж, зориулалтын дагуу үр дүнтэй зарцуулсан эсэх
- ✓ Төсвийн ерөнхийлөн захирагчийн хэрэгжүүлсэн хөтөлбөр арга хэмжээ төлөвлөсөн үр дүнд хүрсэн эсэх
- ✓ Төрөөс хэрэгжүүлж буй төсвийн бодлогыг орон нутагт үр дүнтэй хэрэгжүүлсэн эсэх
- ✓ Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг үр дүнтэй хэрэгжүүлсэн эсэх

# ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ

Сангийн яамнаас Архангай аймгийн 2025 оны төсвийн суурь орлогыг 26,351.4 сая төгрөгөөр, суурь зарлагыг 78,537.8 сая төгрөгөөр хянаж, Монгол Улсын 2025 оны Төсвийн тухай хуулиар аймагт олгох санхүүгийн дэмжлэгийг 52,186.4 сая төгрөгөөр, улсын төсвөөс орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлгийг 14,505.7 сая төгрөгөөр, үүнээс сумдад 8,968.2 сая төгрөгийг хуваарилан баталсан байна.

Харин 2025 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн “Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай” хуулиар Архангай аймагт олгох санхүүгийн дэмжлэгийг 33,894.6 сая төгрөгөөр, улсын төсвөөс Орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлгийг 9,698.4 сая төгрөгөөр баталжээ.

Аймгийн 2025 оны жилийн хөгжлийн төлөвлөгөөг Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр, аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны арга хэмжээний төлөвлөгөө, аймгийн 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлтэй уялдуулан боловсруулан хэрэгжүүлж ажилласан байна. Аймгийн 2025 оны хөгжлийн төлөвлөгөө нь нь ТЕЗ-ийн 31 үр



дүнгийн 46 хөтөлбөрийн хүрээнд 148 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, дэвшүүлсэн зорилт, төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийг 98.3 хувьтай үнэлсэн ба аймгийн ИТХ-ын 2025 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн 08/44 дүгээр тогтоолоор “Үр дүнтэй” гэж дүгнэсэн байна.

Орон нутгийн төсвийн орлого 28,277.9 сая төгрөгийг төвлөрүүлэхээр төлөвлөж, гүйцэтгэлээр нийт 39,284.8 сая төгрөгийн орлого төвлөрүүлж, төлөвлөгөөг 138.9 хувиар буюу 11,006.9 сая төгрөгөөр давуулан биелүүлсэн байна. Тайлант онд төлөвлөсөн 26 нэр төрлийн орлогоос 21 нэр төрлийн орлогыг 11,570.8 сая төгрөгөөр давуулан биелүүлж, 5 нэр төрлийн орлогын төлөвлөгөөг 563.9 сая төгрөгөөр тасалсан байна.

Аймгийн 2025 оны төсвийн нийт зарлагыг 91,776.3 сая төгрөгөөр төлөвлөснөөс 76,403.6 сая төгрөгийг зарцуулж, зардлын гүйцэтгэл 83.2 хувьтай байна. Харин нэмэлт санхүүжилтийн дансаар 4,001.9 сая төгрөгийн санхүүжилт орж, гүйцэтгэлээр 1,785.2 сая төгрөг зарцуулж, 243.5 мянган төгрөгийг аймгийн нэмэлт санхүүжилтийн дансанд татан төвлөрүүлсэн байна.

Аймгийн нэгдсэн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайланд аймаг сумдын төрийн сангийн -20, орон нутгийн 48 төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчийн нийт 110 барилгын ашиглалт, үйлчилгээ (Боловсролын байгууллага 67, эрүүл мэндийн 20, соёлын 22, спортын 1), 41 тусгай сан, аймгийн засаг дарга дансны төлөвлөгөө, гүйцэтгэл нийт 220 байгууллагын төсвийн гүйцэтгэлийн тайланг нэгтгэсэн байна.

# А1. Орон нутгийн 2025 оны төсвийн орлогыг хууль, журамд заасан шаардлагад нийцүүлэн төлөвлөсөн байна

Аймгийн 2025 оны орлогын төсвийн төслийг Сангийн яамнаас ирүүлсэн “Төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2025 оны төсвийн төслийг боловсруулах удирдамж”-ийн хүрээнд нийт орлогыг 20,311.1 сая төгрөгөөр боловсруулан Сангийн яаманд хүргүүлсэнд яамнаас суурь орлогыг нэмэгдүүлэх чиглэлийг баримтлан нийт дүнгээр 32.2 хувь буюу 6,536.1 сая төгрөгөөр нэмэгдүүлэн 26,847.2 сая төгрөгөөр хянасан байна.

Аймгийн ИТХ-ын 2024 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн “Аймгийн 2025 оны төсөв батлах тухай” 03/04 дүгээр тогтоолоор төсөвт байгууллагын өөрийн орлогыг 8.0 сая төгрөгөөр нэмэгдүүлж, 2025 оны төсвийн орлогын нийт дүнг 26,855.1 сая төгрөгөөр баталсан байна.

А1.1 Орон нутгийн 2025 оны төсвийн орлогыг Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн дагуу татварын 20 нэр төрөл, татварын бус 5, хөрөнгийн 1 нийт 26 нэр төрлийн орлогын хүрээнд төлөвлөсөн байна.

## БҮЛЭГ 1

ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ОРЛОГЫН ГҮЙЦЭТГЭЛ НИЙТ ДҮНГЭЭР 138.9 ХУВИАР БУЮУ 11,006.9 САЯ ТӨГРӨГӨӨР ДАВЖ БИЕЛСЭН БАЙНА

Күснэгт 2: Орлого төлөвлөлтийн судалгаа

Үзүүлэлт	Орон нутгаас хүргүүлсэн 2025 оны орлогын төсвийн төсөл		Сангийн Яам хянасан		Орон нутгаас хүргүүлсэн төсөл СЯ-ын хянасан зөрүү	Аймгийн ИТХ-аар анх батлагдсан орлого	СЯ хянасан ба аймгийн ИТХ-ын баталсан орлогын зөрүү
	Суурь орлого	Нийт орлого	Суурь орлого	Нийт орлого			
НИЙТ ОРЛОГО	19,751.1	20,311.1	26,171.4	26,847.2	6,536.1	26,855.1	8.0
ТАТВАРЫН ОРЛОГО	18,141.9	18,701.9	24,129.0	24,804.8	6,102.9	24,804.8	-
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,594.2	1,594.2	2,027.4	2,027.4	433.2	2,035.4	8.0
ХӨРӨНГИЙН ОРЛОГО	15.0	15.0	15.0	15.0	-	15.0	-

Эх сурвалж: Аймгийн ИТХ-ын төсөв баталсан тогтоол, СЯ-аас хянаж ирүүлсэн суурь орлого

Тайлангийн жилд төрийн хэмнэлтийн бодлоготой уялдуулан 2025 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн “Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай” хуулиар улсын төсөвт тодотгол орсонтой холбоотой аймгийн 2025 оны төсөвт тодотгол хийгдэж, төсвийн орлогыг Аймгийн ИТХ-ын 2025 оны 07 дугаар сарын 21-ний өдрийн “Аймгийн 2025 оны төсвийг тодотгон батлах тухай” 06/28 дугаар тогтоолоор 266.4 сая төгрөгөөр бууруулан 26,610.5 сая төгрөгөөр тодотгон баталсан байна. Үүнд:

- Цалин хөлсний орлогын албан татварыг 307.3 сая төгрөгөөр бууруулж,
- Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөрийг 5.4 сая төгрөгөөр,
- Хог хаягдлын үйлчилгээний хураамжийг 57.3 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлжээ.

Аймгийн ИТХ-аар тодотгон баталсан 26,610.5 сая төгрөгийн төсвийн орлого дээр сумд орон нутгийнхаа онцлог байдалтай уялдуулан хуулиар олгогдсон эрх хэмжээнийхээ хүрээнд 3 нэр төрлийн орлогыг 1,667.4 сая төгрөгөөр нэмэгдүүлж, аймгийн ТЕЗ-ийн төсвийн нийт орлого 28,277.9 сая төгрөг болж, Сангийн яамны төсвийн төлөвлөлтийн фискал /fiscal/ программд төлөвлөгдсөн байна.

## A2. Орон нутгийн төсвийн орлого нийт дүнгээрээ 11,006.9 сая төгрөгөөр давж гүйцэтгэл 138.9 хувьтай байна

Орон нутгийн төсвийн нийт орлогыг 28,277.9 сая төгрөгөөр төлөвлөсөн ба гүйцэтгэлээр нийт 39,284.8 сая төгрөгийн орлого төвлөрүүлж, төлөвлөгөөг 138.9 хувиар буюу 11,006.9 сая төгрөгөөр давуулан биелүүлсэн байна.

Хүснэгт 4: Орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл

/сая төгрөгөөр/

№	Үзүүлэлт	2025 оны			
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1.	НИЙТ ОРЛОГО	28,277.9	39,284.8	11,006.9	138.9
2.	УРСГАЛ ОРЛОГО	28,262.9	39,162.4	10,899.5	138.6
3.	ТАТВАРЫН ОРЛОГО	25,877.3	31,085.7	5,208.4	120.1
5.	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	2,385.6	8,076.7	5,691.1	338.6
	ХӨРӨНГИЙН ОРЛОГО	15.0	122.4	107.4	816.0

Эх сурвалж: Архангай аймгийн ТЕЗ-ийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Төсвийн орлогоос 16 нэр төрлийн татварын орлого 120.1 хувиар буюу 5,208.4 сая төгрөгөөр, 4 нэр төрлийн татварын бус орлого 338.5 хувь буюу 5,691.0 сая төгрөгөөр, хөрөнгийн орлого 816.0 хувиар буюу 107.4 сая төгрөгөөр давж биелсэн.

**A2.1 Орон нутгийн төсвийн орлого нийт дүнгээр давж биелсэн хэдий ч, 5 нэр төрлийн орлого 563.9 сая төгрөгөөр тасарсан байна.**

Орон нутгийн төсвийн орлого 5 нэр төрлөөр 563.9 сая төгрөгөөр дутуу төвлөрсний 78.9 хувь буюу 444.8 сая төгрөг нь засгийн газрын дамжуулан зээлийн хүүгийн орлого байна. Үүнд:

- Хүүгийн орлого 444.8 сая төгрөгөөр тасарсан нь Засгийн газрын дамжуулан зээлийн гэрээний эргэн төлөлттэй холбоотойгоор Сангийн яамнаас орон нутгийн суурь орлого дээр нэмж 444.8 сая төгрөгөөр хянасан бөгөөд тус орлогыг Архангайн ус суваг ОНӨААТҮГ нь төлөх эх үүсвэргүй, алдагдалтай ажилласан;
- Үл хөдлөх хөрөнгийн албан татвар 9.7 хувиар буюу 67.6 сая төгрөгөөр тасарсан нь Ар ган ХХК, Магнай трейд ХХК-уудын үйл ажиллагаа зогссоноос болж ногдсон татвараа хуулийн хугацаанд төлөөгүй;
- Галт зэвсгийн албан татвар 0.6 хувиар буюу 0.5 сая төгрөгөөр тасарсан нь Галт зэвсгийг бүртгэлээс хасагдсан, зарагдсан тохиолдолд цагдаагийн газрын бүртгэлээс хасуулаагүй;
- Байгалийн ургамал ашигласны төлбөр 31.5 хувиар буюу 6.3 сая төгрөгөөр тасарсан нь тайлант онд жимс ургаагүй;
- Авто тээвэр болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар 5.6 хувиар буюу 44.8 сая төгрөгөөр тасарсан нь тус орлогын төлөвлөгөө өмнөх оноос 147.0 сая төгрөгөөр өндөр хянагдаж ирсэн бөгөөд албан хаагчид орлогыг жигд ханган биелүүлэхэд анхаарч ажиллаагүйтэй холбоотой байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1 “Хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх” гэсэн заалттай нийцэхгүй байна.

### Шийдвэрлэсэн нь:

Төсвийн тухай хуулийг мөрдөж, орлогыг нэр төрлөөр нь жигд ханган биелүүлэхэд анхаарч ажиллах, орлогын сар улирлын төлөвлөгөөний биелэлтэд хяналт тавьж ажиллах зөвлөмжийг аймгийн Засаг даргад хүргүүлээ.

Б.1.1 Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2025 оны төсвийн зардлын саналыг Сангийн яамнаас ирүүлсэн төсвийн удирдамжийн дагуу боловсруулж хүргүүлсэн ба саналыг 6.8 хувиар бууруулж хянасан байна

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2025 оны төсвийн төсөл бэлтгэх удирдамжид заасны дагуу Архангай аймгийн орон нутгийн 2025 оны төсвийн суурь зарлагын төслийг 77,954.1 сая төгрөгөөр боловсруулж, Сангийн яаманд хүргүүлснийг 5,311.5 сая төгрөгөөр буюу 6.8 хувиар бууруулан 72,633.6 сая төгрөгөөр хянасан байна.

Хүснэгт 5: Сангийн яаманд хүргүүлсэн, анх болон тодотгон хянасан 2025 оны суурь зарлагын судалгаа /сая төгрөгөөр/

Код	Зардлын ангилал	Хүргүүлсэн санал	Сангийн яамны		Зөрүү	
			Анх хянасан	Тодотголоор хянасан	Санал ба анх хянасны /2-1/	Анх хянасан ба тодотголын /3-2/
	А	1	2	3	4	5
2	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>77,945.1</b>	<b>72,633.6</b>	<b>59,821.4</b>	<b>(5,311.5)</b>	<b>(12,812.2)</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>71,445.1</b>	<b>67,897.4</b>	<b>55,473.3</b>	<b>(3,547.7)</b>	<b>(12,424.1)</b>
210	БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	70,074.0	66,138.3	53,958.2	(3,935.7)	(12,180.1)
211	Хүү	-	444.8	444.8	444.8	-
212	ТАТААС	358.1	322.3	273.4	(35.8)	(48.9)
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,013.0	992.0	796.9	(21.0)	(195.1)
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	6,500.0	4,736.2	4,348.1	(1,763.8)	(388.1)

Эх сурвалж: Архангай аймгийн ТЕЗ-ийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

## ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ЗАРЛАГЫН ГҮЙЦЭТГЭЛ 83.2 ХУВЬТАЙ БАЙНА

## БҮЛЭГ 2

Сангийн яамнаас төсвийн тодотголоор аймгийн суурь орлогыг 244.6 сая төгрөгөөр бууруулж 25,296.8 сая төгрөг, суурь зарлагыг 12,812.2 сая төгрөгөөр бууруулж 59,821.4 сая төгрөгөөр хянасан байна.

Цалин хөлс, шимтгэлийг 4.5 хувь буюу 1,428.8 сая төгрөгөөр, хөрөнгийн зардлыг 8.2 хувь буюу 388.1 сая төгрөгөөр, бусад зардлыг 8.0-54.2 хувиар бууруулжээ.

Хүснэгт 6: Урьд оны үлдэгдлийн хуваарилалт /сая төгрөг/

№	Урьд оны үлдэгдлээс санхүүжүүлэх зардлууд -байгууллагаар	Мөнгөн дүн
1	ИТХ-ын төлөөлөгч нарын тойрогт ажиллах зардал, хороодын хуралдааны зардал, ҮАЗ - Аймгийн ИТХ	550.0
2	Баяр наадмын зардал-Аймаг, сумдын ЗДТГ	108.9
3	Засаг даргын нөөц хөрөнгийн зардал-Аймгийн ЗДТГ	1157.5
4	Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр хэрэгжүүлэх зардал-Засаг дарга данс	725.0
5	Архивын хэлтэс	86.6
6	Цэцэрлэг хотын хот тохижилтын үйлчилгээний зардал-ХТҮГ	280.0
7	Мал хамгаалах сан	80.0
8	Орон нутгийн авто замын сан	116.0
Нийт дүн		3,104.0

Эх сурвалж: Аймгийн ИТХ-ын төсөв баталсан тогтоол

Сангийн яамны тодотгон хянасан аймгийн төсвийн суурь орлого, зарлагын дүн 59,821.4 сая төгрөгийг ОНХС-ийн орлогын шилжүүлэг 11,013.5 сая төгрөг, урьд оны үлдэгдлээс 3,104.0 сая төгрөг, нийт 14,117.5 сая төгрөгөөр нэмэгдүүлж төсвийг 73,938.9 сая төгрөгөөр тодотгон баталжээ.

Аймгийн ИТХ-ын 2025 оны 07 дугаар сарын 21-ний өдрийн “Аймгийн 2025 оны тодотгосон төсөв батлах тухай” 06/28 дугаар тогтоолоор 2025 оны төсвийн жилд зарцуулах зарлагын нийт дүнг 17,837.4 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, төсвийг 91,776.3 сая төгрөгөөр төлөвлөж, тайлагнасан байна. Нэмэгдсэн дүнг зардалж харуулбал:

- Сумдын ИТХ 893.2 сая төгрөгөөр,
- Сумдын ЗДТГ 8,798.2 сая төгрөгөөр,
- Сум дундын ойн анги 243.4 сая төгрөг,
- ОНХС-г 3,906.0 сая төгрөгөөр,
- Хоршоо хөгжүүлэх санг 3,864.1 сая төгрөгөөр,
- ТБОНӨ-ийн барилга, ашиглалтын зардлыг 132.4 сая төгрөгөөр нэмжээ.

## Б.1.3 Аймгийн ТЕЗ-ийн 2025 оны төсвийн гүйцэтгэл 76,403.6 сая төгрөг буюу 83.2 хувьтай байна

Аймгийн 2025 оны төсвийн гүйцэтгэлийн нийт зарлага фискал /fiscal/ программд /төсвийн гүйцэтгэлийн тайлангаар/ 91,776.3 сая төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр 76,403.6 сая төгрөгийг зарцуулан, төсвийн гүйцэтгэл 83.2 хувьтай тайлагнагджээ.

Хүснэгт 8: Орон нутгийн 2025 оны төсвийн зарлагын төлөвлөгөө, гүйцэтгэлийн судалгаа /сая төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	2024 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл		2025 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл				Тайлант оны төлөвлөгөө өмнөх оны төлөвлөгөөг харьцуулбал	Тайлант оны гүйцэтгэл өмнөх оны гүйцэтгэл
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь		
0	1	2	3	4	5	6	7=3-1	8=4-2
Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	85,719.7	73,194.8	91,776.3	76,403.6	15,372.7	83.2	6,058.6	3,209.0
А. Урсгал зардал	57,883.5	52,782.5	64,323.9	56,538.0	7,785.9	87.9	6,440.4	3,775.5
Б. Хөрөнгийн зардал	23,922.5	19,783.5	23,201.6	18,333.9	4,867.7	79.0	(720.9)	(1,429.6)
В. Эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээл	3,913.7	688.8	4,250.8	1,531.7	2,719.1	36.0	337.1	863.1

Эх сурвалж: Архангай аймгийн ТЕЗ-ийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Төсвийн гүйцэтгэлийн нийт зардал төлөвлөснөөс 15,372.7 сая төгрөгөөр дутуу буюу 83.2 хувиар тайлагнасан нь дараах шалтгаантай байна. Үүнд:



- Аймаг, сумын удирдлагын байгууллагуудын төсөвт зардлаас 5,592.4 сая төгрөг, ТБОНӨ-ийн барилгын ашиглалтын зардлаас 1,749.4 сая төгрөг, нийт 7,341.8 сая төгрөгийг хэмнэж төвлөрүүлсэн,
- Хөрөнгийн зардалд төлөвлөсөн 4,867.8 сая төгрөгийн төсөл, арга хэмжээг дараа он руу шилжүүлсэн,

- Сумдын ХХС-ийн зээлийн эргэн төлөлт хангалтгүй, төсөл сонгон шалгаруулалтад шаардлага хангасан хоршоо оролцоогүйгээс шалтгаалж, төлөвлөгдсөн 2,719.1 сая төгрөгийн зээл олгогдоогүй байна.

Дүрслэл № 4: Байр ашиглалтын зардлын төлөвлөгөө



Хүснэгт 11: Байр ашиглалтын зардлын төлөвлөгөө, гүйцэтгэл /сая төгрөгөөр/

Салбарын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хэмнэлт, хэтрэлт	Гүйцэтгэл /хувиар/
Эрүүл мэнд	2,880.5	2,679.2	201.3	93.0
Соёл урлаг	1,774.9	1,221.8	553.1	68.8
Ерөнхий боловсрол	6,320.1	6,074.8	245.3	96.1
Сургуулийн өмнөх боловсрол	2,557.7	2,331.6	226.1	91.2
Биеийн тамир спорт	1,368.9	906.2	462.7	66.2
Мэргэжлийн боловсрол	261.7	200.8	60.9	76.7
<b>Нийт дүн</b>	<b>15,163.8</b>	<b>13,414.4</b>	<b>1,749.4</b>	<b>492.1</b>

Эх сурвалж: Архангай аймгийн ТЕЗ-ийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд сумын төсөвт олгох санхүүгийн дэмжлэг 100 хувь бүрэн олгогдсон, ТБОНӨ-ийн барилга ашиглалтын зардалд 15,031.4 сая төгрөгийг төлөвлөж, 13,414.4 сая төгрөгийг зарцуулсан ба гүйцэтгэл 88.5 хувьтай байна

В.1.1 Аймгийн ТЕЗ-ийн 2025 онд хэрэгжүүлэх хөтөлбөрийн зорилт, хүрэх үр дүн, хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоон хэмжээний шалгуур үзүүлэлт, хүрэх түвшнийг тодорхойлон баталсан байна


Төсвийн тухай хулийн 54 дүгээр зүйлийн 54.5.1<sup>[1]</sup>, 54.5.3<sup>[2]</sup>, 54.5.4<sup>[3]</sup>, 54.5.5<sup>[4]</sup>-д заасны дагуу аймгийн ТЕЗ-ийн 2025 оны төсвийн гүйцэтгэлийн тайланг ирүүлсэн байна.

Аймгийн ТЕЗ-ийн 2025 оны хөтөлбөр арга хэмжээнд зарцуулсан төсөв, хүрсэн үр дүнгийн тайлангаар 70417-Мэргэжлийн хяналт, 70801-Мал аж ахуйг хөгжүүлэх, 71411-Хүрээлэн буй орчны бодлого, удирдлага хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн арга хэмжээнд зарцуулсан төсвийн гүйцэтгэл 93.1-99.2 хувьтай, үр ашиг 50.4-73.3 хувьтай байна.

Харин төсвийн гүйцэтгэл 86.6-100.0 хувьтай боловч үр ашиг 0 хувьтай байгаа хөтөлбөрүүдийн үр ашгийг нэмэгдүүлэхэд анхаарч ажиллах нь зүйтэй байна

## БҮЛЭГ 3

ОРОН НУТГИЙН ТЕЗ-ИЙН 2025 ОНЫ ХӨТӨЛБӨР АРГА ХЭМЖЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТ ДУНДЖААР 83.2 ХУВЬТАЙ БАЙНА



# В.2.1 Төсвийн хөрөнгө оруулалтын зардлыг журмын дагуу төлөвлөж, зарцуулсан байна



## АВТО ЗАМЫН САН

Аймгийн ИТХ-ын 2025 оны 06/28 дугаар тогтоолоор авто замын сангийн хөрөнгөөр 1,473.0 сая төгрөгийн 1 төсөл арга хэмжээг он дамжин хэрэгжүүлэхээр баталсан ба гүйцэтгэлээр 1,152.1 сая төгрөгийн санхүүжилтийг гэрээний дагуу олгож, дараа онд 320.9 сая төгрөгийг олгохоор байна.



## ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ



ИТХ-ын тогтоол /2024.12.20/

**4,736.2** /сая.төг/ **17** /төсөл, арга хэмжээ/



ИТХ-ын тогтоол /2025.07.21/

**3,315.3** /сая.төг/ **11** /төсөл, арга хэмжээ/



Гүйцэтгэл /Олгосон санхүүжилт/

Бүрэн хэрэгжсэн

**2,351.0** /сая.төг/ **8** /төсөл, арга хэмжээ/

Он дамжин хэрэгжих

**906.0** /сая.төг/ **3** /төсөл, арга хэмжээ/



Барьцаа хөрөнгийн дансанд

**58.3** /сая.төг төвлөрүүлсэн/

Дараах 3 ТАХ он дамжин хэрэгжиж байна. Үүнд:

- Цэцэрлэг сумын ЕБС-ийн их засвар
- Өндөр-улаан сумын ЕБС-ийн 80 ортой дотуур байрны их засвар
- Эрдэнэмандал сумын ЕБС-ийн их засвар

## ОРОН НУТГИЙН ХӨГЖИЙН САН



Аймгийн ОНХС

Сумдын ОНХС

МУ-ын 2025 оны төсвөөр баталсан

**3,614.5** сая.төг

**6,083.8** сая.төг



Аймгийн ИТХ-ын тогтоол /2025.07.21/

**4,929.7** сая.төг

**9,989.8** сая.төг

17 төсөл арга хэмжээ

258 төсөл арга хэмжээ



Тайлант оны төсвийн гүйцэтгэл

**4,217.6** сая.төг

**6,673.8** сая.төг

16 төсөл арга хэмжээ

182 төсөл арга хэмжээ



ОНХС-ын мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

**573.4** сая.төг

**3,343.9** сая.төг

1 төсөл арга хэмжээ

76 төсөл арга хэмжээ

АМРАЛТЫН ИХ ЗАСВАР  
ӨРТӨГ: 771.05 САЯ



ЭРДЭНЭ  
СУУРЬШЛ  
АГ  
ТӨСӨВ



ХОТ ТОХИЖИЛТ,  
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТУСГАЙ  
ЗОРИУЛАЛТЫН АВТО  
МАШИН  
ТӨСӨВТ ӨРТӨГ: 243.9 САЯ



В.2.2 Нэмэлт төсвийн орлого 4,001.9 сая төгрөг ба гүйцэтгэлээр 1,785.2 сая төгрөгийг зориулалтын дагуу зарцуулж тайлагнасан байна

Тайлант онд аймгийн ТЕЗ-ийн харьяа 44 байгууллага нэмэлт санхүүжилтээр нийт 4,001.9 сая төгрөгийг хүлээн авч, 1,785.2 сая төгрөг зарцуулагдсан ба 18 байгууллагын зарцуулагдаагүй үлдэгдэл болох 243.5 мянган төгрөгийг аймгийн нэмэлт санхүүжилтийн 100010051499 тоот дансанд татан төвлөрүүлжээ.

## НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТ

Харин Жаргалант сумын нэмэлт санхүүжилтийн дансаар орсон 1,973.2 сая төгрөгийн самрын болон самрын дуудлага худалдааны орлогыг ойн нөөц ашигласны төлбөрийн орлогод шилжүүлж, орон нутгийн төсөвт төвлөрсөн байна.

Нэмэлт санхүүжилтийн гүйцэтгэлийн тайланг өмнөх онтой харьцуулахад нийт зардал өмнөх оноос 1.3 дахин өссөн ба нийт зардлын 56.0 хувь буюу 999.5 сая төгрөг нь урсгал зардал, 44 хувь буюу 785.7 сая төгрөг нь хөрөнгийн зардалд зарцуулагджээ.

Хүснэгт 17: Аймгийн ТЕЗ-ийн 2025 оны нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан /сая төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	2,986.2	4,001.9	1,015.7	134.0
12213	Нэмэлт санхүүжилтийн орлого	2,986.2	4,001.9	1,015.7	134.0
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,593.3	1,785.2	(808.1)	68.8
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,265.8	999.5	(1,266.3)	44.1
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,261.1	999.5	(1,261.6)	44.2
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	32.1	71.1	39.0	221.2
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	4.0	8.9	4.9	221.4
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	-	1.7	1.7	-
2104	Хангамж, бараа материалын зардал	75.5	62.9	(12.6)	83.3
2105	Нормативт зардал	1.7	2.5	0.8	148.8
2106	Эд хогшил, урсгал заварын зардал	74.4	48.7	(25.7)	65.5
2107	Томилолт, зочны зардал	4.8	13.5	8.7	280.7
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	429.0	207.8	(221.2)	48.4
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,639.7	582.4	(1,057.3)	35.5
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	4.7	-	(4.7)	-
2132	Бусад урсгал шилжүүлэг	4.7	-	(4.7)	-
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	327.5	785.7	458.2	239.9
4	ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	392.9	2,216.7	1,823.8	564.2
5	АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	(392.9)	(2,216.7)	(1,823.8)	564.2

## ГАМШГААС ХАМГААЛАХ ЗАРДАЛ

Аймгийн ТЕЗ-ийн гамшгаас хамгаалах арга хэмжээний зардалд 300.0 сая төгрөгийг төлөвлөж, тодотголоор төсөв өөрчлөгдөөгүй байна. Тайлант онд 50.0 сая төгрөг дутуу буюу 250.0 сая төгрөгийн санхүүжилтийг авсан ба гүйцэтгэлээр 200.2 сая төгрөгийг зарцуулж, 49.8 сая төгрөгийг төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Дүрслэл № 5: Гамшгаас хамгаалах зардлын гүйцэтгэл



Гамшгаас хамгаалах зардлыг урьд онтой харьцуулахад төлөвлөгөө 300.0 сая төгрөг буюу 54.6 хувь, гүйцэтгэл 200.2 сая төгрөг буюу 45.3 хувиар өссөн байна. Энэ нь тайлант жил өмнөх оноос харьцангуй цаг агаарын аюулт үзэгдэл, үерийн гамшиг бага тохиолдсонтой холбоотой байна.

Contact Person:

More Information:

[www.reallygreatsite.com](http://www.reallygreatsite.com)

# ХӨТӨЛБӨР ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗАРДАЛ

Аймгийн засаг даргын 2025 оны үйл ажиллагааны хөтөлбөр хэрэгжүүлэх зардалд 1,497.8 сая төгрөгийг зарцуулж, гүйцэтгэл 95.1 хувьтай байна

Аймгийн ИТХ-ын 2025 оны 07 дугаар сарын 21-ний өдрийн “Аймгийн 2025 оны төсвийг тодотгон батлах тухай” 06/28 дугаар тогтоолоор хөтөлбөр хэрэгжүүлэх зардлыг 1,575.0 сая төгрөгөөр баталсан ба тайлант онд 60.0 сая төгрөг дутуу буюу 1,515.0 сая төгрөгийн санхүүжилтийг авч, гүйцэтгэлээр 1,497.8 сая төгрөгийг зарцуулж, 17.2 сая төгрөгийг төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

## ХҮНИЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО

### БОЛОВСРОЛ

ТӨЛ **386.1** /сая.төг  
ГҮЙ **386.1** /сая.төг

### ЭРҮҮЛ МЭНД

ТӨЛ **236.1** /сая.төг  
ГҮЙ **236.1** /сая.төг

### БИЕИЙН ТАМИР

ТӨЛ **50.0** /сая.төг  
ГҮЙ **45.0** /сая.төг

### НИЙГМИЙН ХАМГААЛАЛ

ТӨЛ **65.0** /сая.төг  
ГҮЙ **60.1** /сая.төг

### ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ

ТӨЛ **150.0** /сая.төг  
ГҮЙ **94.6** /сая.төг

## ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО

### БАЙГАЛЬ ОРЧИН

ТӨЛ **100.0** /сая.төг  
ГҮЙ **99.6** /сая.төг

### СОЁЛ УРЛАГ

ТӨЛ **75.0** /сая.төг  
ГҮЙ **75.0** /сая.төг

### АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ

ТӨЛ **100.0** /сая.төг  
ГҮЙ **100.0** /сая.төг

### ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ ХӨНГӨН ҮЙЛДВЭР

ТӨЛ **150.0** /сая.төг  
ГҮЙ **150.0** /сая.төг

## ХҮНИЙ ЭРХИЙГ ДЭЭДЭЛСЭН ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО

### ХҮНИЙ НӨӨЦ

ТӨЛ **166.8** /сая.төг  
ГҮЙ **165.1** /сая.төг

### САНХҮҮ ТӨСӨВ

ТӨЛ **52.0** /сая.төг  
ГҮЙ **50.8** /сая.төг

### ХУУЛЬ ЭРХ ЗҮЙ

ТӨЛ **24.0** /сая.төг  
ГҮЙ **16.0** /сая.төг

## БҮСЧИЛСЭН ХӨГЖЛИЙН БОДЛОГО

### САЛБАР БҮРТ

ТӨЛ **20.0** /сая.төг  
ГҮЙ **19.4** /сая.төг

Засаг даргын хөтөлбөр хэрэгжүүлэх зардлыг ангилж үзэхэд сургалтын үйл ажиллагааны дэмжлэгт 280.2 сая төгрөг, тэтгэмж, урамшуулалд 581.5 сая төгрөг, тэмцээн уралдааны дэмжлэгт 45.0 сая төгрөг, байгаль орчин, аялал жуулчлалын үйл ажиллагаанд 174.6 сая төгрөг, цалин хөлсний дэмжлэгт 327.5 сая төгрөг, бусад зардалд 89.0 сая төгрөгийн зардал гүйцэтгэлээр гарсан байна.

# ХӨТӨЛБӨР ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗАРДЛЫН ГҮЙЦЭТГЭЛ

Тайлант онд аймгийн засаг даргын ерөнхий дансанд хөтөлбөр хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас багш, эмч, сувилагч нарыг шагнаж урамшуулахад нийт 524.2 сая төгрөгийг хэт хавтгайруулан зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “Төсвийг үр ашигтай хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д “Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно: 15.1.3-т Хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох” гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Төсвийн тухай болон Төрийн хэмнэлтийн тухай хуулийг мөрдөж, Засаг даргын хөтөлбөр хэрэгжүүлэх арга хэмжээний зардлыг үр ашигтай хэмнэлттэй байхаар төлөвлөж, үр дүнтэй зарцуулахад анхаарч ажиллах албан шаардлагыг аймгийн Засаг даргад хүргүүлээ.

Аймгийн ИТХ-ын 2025 оны 07 дугаар сарын 21-ний өдрийн “Аймгийн 2025 оны төсвийг тодотгон батлах тухай” 06/28 дугаар тогтоолоор “Тунгалаг тамир цогцолбор” ОНӨААТҮГ-ын үйл ажиллагаанд 2025 оны хөтөлбөр хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас 150.0 сая төгрөгийг баталж, гүйцэтгэлээр 94.6 сая төгрөгийг цалингийн зардалд зарцуулсан байна.

**Шийдвэрлэсэн нь:** Төсвийн тухай болон Төрийн хэмнэлтийн тухай хуулийг мөрдөж, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дэмжлэг олгохгүй байх, төсвийг үр ашигтай хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулахад анхаарч ажиллах албан шаардлагыг аймгийн Засаг даргад хүргүүлээ.



## ХОТЫН НИЙТИЙН ХҮН ТЭЭВРИЙН ЗАРДЛЫН ГҮЙЦЭТГЭЛ

Тайлант онд аймгийн засаг даргын ерөнхий дансанд хотын нийтийн хүн тээврийн үйлчилгээнд 273.4 сая төгрөгийг зарцуулахаар төлөвлөж зарцуулсан байна. Энэхүү арга хэмжээг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулж Нутаг хүнс ХХК-тай гэрээ байгуулан гүйцэтгүүлжээ.



## АХМАД НАСТНЫ ХӨГЖИЛ ХАМГААЛЛЫН ЗАРДЛЫН ГҮЙЦЭТГЭЛ

Аймгийн засаг даргын ерөнхий дансанд ахмад настны хөгжил хамгааллын зардалд анх 128.5 сая төгрөгийг баталсан ба тодотголоор 45.6 сая төгрөгөөр бууруулан 82.9 сая төгрөгийг зарцуулахаар баталж, гүйцэтгэлээр санхүүжилтийг 100 хувь бүрэн олгосон байна.

Ахмадын хорооны мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 1.4 сая төгрөг ба тайлант онд 118.5 сая төгрөгөөр нэмэгдэж, үл ажиллагааны зардалд 119.8 сая төгрөгийг зарцуулж, эцсийн үлдэгдэл 0.1 сая төгрөг байна. Ахмадын хорооны 2025 оны санхүүгийн тайланд Ворлдвайд фاینэнс аудит ХХК аудит хийж дүгнэлт гаргасан байна.

## БҮЛЭГ 4

### Г.1.2 Тайлант хугацаанд аудитад баримталсан ерөнхий чиглэлийн чиглэлийн судалгаанд аймгийн ТЕЗ-ийн харьяа 59 байгууллага хамрагдсан

Аймгийн ТЕЗ-ийн санхүүгийн нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайланд нэгтгэгдэх харьяа байгууллагаас 8-н төрлийн судалгааг санхүүгийн тайлангийн аудитаар авч, дүнг нэгтгэн танилцуулж байна. Судалгаанд төсвийн шууд захирагчийн 48, ОНӨҮГ-ын 11 нийт аймгийн ТЕЗ-ийн харьяа 59 байгууллага хамрагдсан.

#### УНАА, ХООЛНЫ ХӨНГӨЛӨЛТ

Аймгийн ТЕЗ-ийн харьяа 59 байгууллагын унаа, хоолны хөнгөлөлтийн зардлын судалгаагаар 23 байгууллагад 761.6 сая төгрөгийн төсөв батлагдаж, гүйцэтгэлээр 37 байгууллагатай холбоотой 1,004.0 сая төгрөгийн унаа хоолны хөнгөлөлт олгогдож, төсвийг 242.4 сая төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан зөрчилд албан шаардлага хүргүүллээ.

#### ГАДААД ТОМИЛОЛТ

Гадаад томилолт, арга хэмжээний зардлын судалгааг авч нэгтгэхэд Засаг даргын нөөц хөрөнгөөс гадаад арга хэмжээний онгоцны тийз, томилолтын зардалд нийт 60.3 төгрөгийг зарцуулагдаж, аудитаар төсөв захирагчид албан шаардлага хүргүүлсэн байна.

#### ТӨРД УЧРУУЛСАН ХОХИРОЛ

Төрд учруулсан хохирол барагдуулах зардлын нэгтгэл судалгаагаар 66.7 сая төгрөгийн төрд учруулсан хохирол нэгтгэгдсэн ба уг зөрчлийг Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйлийн дагуу гэм буруутай этгээдээр буцааж төлүүлэх арга хэмжээг авч ажиллах албан бичгийг холбогдох газарт уламжласан байна.

#### ПРОГРАММ ХАНГАМЖ

Программ хангамжийн судалгаанд 105.7 сая төгрөгийн 9 нэр төрлийн 104 ш программ бүртгэлтэй ба нийт программ хангамжийн 60.7 хувь буюу 64.2 сая төгрөгийн нягтлангийн программ 50 байгууллагад, 11.0 хувь буюу 11.6 сая төгрөгийн нярвын программ 18 байгууллагад, 9.8 хувь буюу 10.4 сая төгрөгийн төрийн сангийн программ 10 байгууллагад, 18.5 хувь буюу 19.5 сая төгрөгийн бусад 6 нэр төрлийн программ хангамж 26 байгууллагад тус тус бүртгэлтэй байна.

#### СУРГАЛТ, СЕМИНАР, ХУРАЛ ЗӨВЛӨГӨӨН

Судалгааны нэгтгэлээр 34 байгууллагатай холбоотой нийт 159.2 сая төгрөгийн 52 арга хэмжээг төлөвлөж, тайлант онд 441.0 сая төгрөгийн 62 арга хэмжээг хэрэгжүүлжээ. Судалгаанаас харахад 10 арга хэмжээг урьдчилан төлөвлөөгүй зохион байгуулсан, арга хэмжээний төсвийг бодит тооцоо судалгаанд үндэслэж төлөвлөөгүйгээс төсөв хэтрүүлэн зарцуулагдах эрсдэл үүссэн байна.

#### ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН СУДАЛГАА

Судалгаанд 11,582.0 сая төгрөгийн орон нутгийн өмчийн хувь оролцоотой, 41,128.5 сая төгрөгийн нийт хөрөнгөтэй 11 ОНӨҮГ хамрагдаж, тайлант онд нийт 5,884.9 сая төгрөгийн орлого бүрдүүлж, гүйцэтгэлээр 5,844.0 сая төгрөгийг зарцуулсан байна. Судалгаанаас харахад ихэнх ОНӨҮГ нь тайлант онд алдагдалтай, авлага, өр төлбөрийн үлдэгдэл ихтэй, үр ашиггүй ажилласан байна.

#### БҮТЭЦ, ОРОН ТОО

Судалгаанд ТЕЗ-ын харьяа 48 байгууллага хамрагдсан ба батлагдсан орон тоо 747, гүйцэтгэлээр 716 орон тоогоор ажиллаж 37 орон тоо дутуу буюу царцаагдсан, 6 орон тоогоор хэтрүүлэн ажилласан байна. Цалингийн санг анх нийт 26,352.1 сая төгрөгөөр баталсан ба тодогголоор 1,631.8 сая төгрөгөөр бууруулж, гүйцэтгэлээр 23,350.7 сая төгрөгийг зарцуулсан байна. Аудитаар зөрчлийг арилгах албан шаардлага ТЕЗ-д хүргүүллээ.

#### ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН ЗАРДАЛ

Судалгаагаар авч нэгтгэн үзэхэд тайлант онд 12 төсвийн шууд захирагч 10 хэвлэл мэдээллийн байгууллагатай нийт 141.9 сая төгрөгийн 19 хамтран ажиллах гэрээг байгуулан ажилласан ба гүйцэтгэлээр 139.8 сая төгрөгийг гэрээний дагуу шилжүүлсэн байна. Сонин хэвлэлтэй 15.9 хувь, телевизтэй 63.0 хувь, цахим сайттай 18.2 хувь нь хамтран ажилласан байна.

Аймгийн ТЕЗ-ийн 2024 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн аудитаар нийт 592.6 сая төгрөгийн зөрчил илэрсэнд аудитаас хууль журмын хэрэгжилтийг хангуулах, дотоод хяналтыг хэрэгжүүлэх 2 заалт бүхий зөвлөмж, зөрчлийг арилгуулах 3 албан шаардлага хүргүүлж, шийдвэрийн хэрэгжилт 88.3 хувьтай байна. Харин орон нутгийн 2025 оны төсвийн төсөлд дүгнэлт өгөх аудитаар 838.1 сая төгрөгийн 5 албан шаардлагыг хүргүүлж, зөвлөмжийн биелэлт 78.6 хувьтай байна.

Иймд өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг үнэлэхэд биелэлт дундажаар 82.4 хувьтай байна.

Нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн аудитаар нийт 980.4 сая төгрөгийн зөрчил илэрсэнд зөрчлийг арилгуулах 861.3 сая төгрөгийн 4 албан шаардлага, орлогын бүрдүүлэлттэй холбоотой 119.1 сая төгрөгийн зөрчилд 1 зөвлөмжийг аймгийн Засаг даргад хүргүүлээ.

## ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна.

- Архангай аймагт Канад улсын “Каталист Плас” байгууллага, Канад Улсын Засгийн газрын санхүүжилтээр “Тэгш хүртээмжтэй засаглалын төлөөх бүтээлч манлайлал /I-LEAD/ төсөл хэрэгжиж, төслийн хүрээнд Тэгш хүртээмжтэй төрийн цахим үйлчилгээг бэхжүүлэх, Жендерийн хариуцлагатай төсөвлөлт хэрэгжүүлэх, Төрийн байгууллагуудын хяналт-шинжилгээ, үнэлгээний чадавхыг бэхжүүлэхэд дэмжлэг үзүүлэхээр байна. Иймд дараа оны орон нутгийн төсвийн төлөвлөлтөд жендерийн хариуцлагатай төсөвлөлтийг хэрэгжүүлж ажиллахад анхаарах нь зүйтэй байна.
- Орон нутгийн төсвийн орлого нийт дүнгээрээ 11,006.9 сая төгрөгөөр давж гүйцэтгэл 138.9 хувьтай байна.
- Орон нутгийн төсвийн орлого нийт дүнгээр давж биелсэн хэдий ч, 5 нэр төрлийн орлого 563.9 сая төгрөгөөр тасарсан байна.
- Аймгийн ИТХ-ын 2025 оны 06/28 тогтоолоор тодотгон баталсан нийт зарлагын дүнг 17,837.4 сая төгрөгөөр нэмэгдүүлэн төсвийн гүйцэтгэлийг 91,776.3 сая төгрөгөөр төлөвлөж тайлагнасан байна.
- Аймгийн ТЕЗ-ийн 2025 оны төсвийн гүйцэтгэл 76,403.6 сая төгрөг буюу 83.2 хувьтай байна.
- Төсвийн жилд төрийн өмчийн барилга ашиглалтын зардалд 15,031.4 сая төгрөгийг төлөвлөж, 13,414.4 сая төгрөгийг зарцуулсан ба гүйцэтгэл 88.5 хувьтай байна.
- Аймгийн ТЕЗ-ийн хэрэгжүүлэх хөтөлбөр арга хэмжээг хууль тогтоомжид нийцүүлэн төлөвлөж, хэрэгжилтийг хангаж ажилласан байна
- Нэмэлт төсвийн орлого өмнөх оноос 1,015.7 сая зориулалтын дагуу зарцуулж тайлагнасан байна
- Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт 82.4 хувьтай байна.

# АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

## АУДИТЫН ЗӨВЛӨМЖ

Аудитын дүнд үндэслэн дараах зөвлөмжийг хүргүүлж байна.

### Аймгийн Засаг дарга Б.Цэрэннадмид танаа

Орлогыг нэр төрлөөр нь жигд ханган биелүүлэхэд анхаарч, орлогын сар улирлын төлөвлөгөөний биелэлтэд хяналт тавьж ажиллах

Зөвлөмжийн биелэлтийг тооцож, холбогдох нотлох баримтын хамт 2025 оны 11 дүгээр сарын 01-ний дотор Архангай аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлнэ үү.

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл /сая.төгрөг/

Зөрчлийн утга	Үүнээс							
	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Тайлан онд төсвийн орлогын төлөвлөгөө нийт дүнгээр 11,006.9 сая төгрөгөөр биелсэн боловч 4 нэр төрлийн нийт 119.1 сая төгрөгөөр тасарсан байна.	1	119.1					1	119.1
Тайлант онд аймгийн засаг даргын ерөнхий дансанд хөтөлбөр хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас багш, эмч, сувилагч нарыг шагнаж урамшуулахад нийт 524.2 сая төгрөгийг хэт хавтгайруулан зарцуулсан байна.	1	524.2			1	524.2		
Аймгийн засаг даргын 2025 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн А/10 дугаар захирамжаар "Тунгалаг тамир цогцолбор" ОНӨААТҮГ-ын үйл ажиллагаанд 2025 оны хөтөлбөр хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас 94.6 сая төгрөгийг урсгал үйл ажиллагааны зардалд дэмжлэг олгосон байна.	1	94.6			1	94.6		
Тайлант онд аймгийн ТЕЗ-ийн харьяа 59 байгууллагын унаа хоолны хөнгөлөлтийн зардлыг судалгаагаар унаа хоолны хөнгөлөлтийг 242.4 сая төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан байна.	1	242.4			1	242.4		
Аймгийн ТЕЗ-д харьяалагдах 48 байгууллагын хэмжээнд санхүүгийн аудитын явцад авсан судалгаагаар батлагдсан орон тоо 747, гүйцэтгэлээр 716 орон тоогоор ажиллаж 37 орон тоо дутуу буюу сул, 6 орон тоог хэтрүүлэн ажилласан байна.	1	-			1	-		
Нийт дүн	5	980.3			4	861.2	1	119.1